



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 111,072,490.00 (нэг зуун арван нэгэн сая далан хоёр мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАВАА

0002790



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээж босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)	Эзэмшигч байгууллагын нэрс
1	Соната-5, 07-97 УБЗ, арал № КМНСМНІАРЗАВ93441	2003/ 2003	154,6	16,500,000.00	16,500,000.00	0	0	1,000,000.00	250,000.00	ГЕГ-ын үйлчилгээ, аж ахуйн алба
2	Тоёота Таун ACE, 20-32 УБӨ, арал № SR40-0152824	1999/ 2007	220,3	7,949,200.00	7,949,200.00	0	0	1,000,000.00	250,000.00	ГЕГ-ын үйлчилгээ, аж ахуйн алба
3	Элентра, 62-92 УБЗ арал № КМНДУ41ВР7U214400	2005/ 2006	332,0	20,038,000.00	20,038,000.00	0	0	500,000.00	125,000.00	Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар
4	УАЗ-469, 36-66 ХОА арал № XLL31512280557030	2001/ 2010	88,6	14,000,000.00	14,000,000.00	0	0	500,000.00	125,000.00	Ховд аймаг Булган дахь Гаалийн газар
5	УАЗ-31514, 64-33 УБЭ, арал № 10014009	2001/ 2001	832,0	5,700,000.00	5,700,000.00	0	0	500,000.00	125,000.00	Дорноговь аймаг Замын- Үүд дэх Гаалийн газар
6	Ниссан Патрол, 02-08 УНУ, арал № CSY61Z0679309	2011/ 2011	209,0	44,285,290.00	44,285,290.00	0	0	1,500,000.00	375,000.00	Хөвсгөл аймаг Ханх дахь Гаалийн хороо

7	Пад Пад трактор, арал№ АСУ300006900	2003/ 2014	12,3	2,600,000.00	2,600,000.00	0	0	300,000.00	75,000.00	Өмнөговь аймаг Шивээхүрэн дэх Гаалийн газар
	Нийт дүн			111,072,490.00 (нэг зуун арван нэгэн сая далан хоёр мянга дөрвөн зуун ерэн)	111,072,490.00 (нэг зуун арван нэгэн сая далан хоёр мянга дөрвөн зуун ерэн)	0	0	5,300,000.00 (таван сая гурван зуун мянган)		